

## АЖИЛТНЫ ӨРГӨДӨЛ ХЯНАСАН ТУХАЙ ТАЙЛАН

2023 оны 3 дугаар сарын 13

Хэрлэн сум

Инженерийн албаны тооцооны техникч ажилтай Д.Бүтэмжидээс өөрийн нь албан тушаалтай ижил цалингийн нэг сүлжилд байсан Захиргаа удирдлагын хэлтсийн Бичиг хэргийн ажилтны цалинг 2 шатлал ахиулан нэмэгдүүлсэн нь үндэслэлтэй эсэхийг хянаж, аудит хийж өгөхийг хүссэн өргөдөл ирүүлсэн байна. Ажилтан Д.Бүтэмжид өргөдлөө Захиргаа удирдлагын хэлтэс болон Үйлдвэрчний эвлэлийн хороонд өгч хариу авсан байна. Тус 2 хариуг үндэслэлгүй гэж үзээд Төлөөлөн удирдах зөвлөл болон Дотоод хяналтын албанд дахин өргөдөл гаргажээ.

ЗУХ-ийн Бичиг хэргийн ажилтны цалин 2023 оны 1 дүгээр сараас “ДБЭХС ТӨХК-ийн инженер техникийн ажилтан ба зарим албан тушаалтны сарын цалингийн жишиг”-ийн 1 дүгээр шатлалаас 3 дугаар шатлал руу дэвшиж үндсэн цалин 598,070 төгрөгөөр нэмэгдэж, Захирлын туслахын цалин 3 дугаар шатлалаас 2 дугаар шатлалд шилжиж 272,720 төгрөгөөр буурсан байна.

Дээрх 2 ажилтны цалингийн шатлалыг өөрчлөх болсон бодитой үндэслэлийг ЗУХ тайлагнаагүй байна.

Төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын зэрэглэлээр Захирлын туслахын албан тушаалыг зарчмын хувьд аймгийн Засаг даргын туслахтай дүйцүүлж үзвэл тус албан тушаал нь ТЗ-8 шатлалаар цалинждаг бөгөөд үндсэн цалин нь 1,286,967 төгрөг байна. Харин архив-бичиг хэргийн эрхлэгчийн албан тушаал нь ТҮ-5 ангилалд хамаарч 716,493 төгрөгийн үндсэн цалинтай байна.

Иймд Архив бичиг хэргийн ажилтны албан тушаал Захирлын туслахын албан тушаалаас шатлал дээр байх үндэслэл байхгүй байна.

Ажилтан Д.Бүтэмжидийн өргөдөлд ҮЭХ-оос хариу өгөхдөө Маргаан таслах комиссыг хуралдуулж хариу өгөх талаар дурджээ. Компанийн Маргаан таслах комисс 2022 оны 12 сарын 13-ны өдөр Гүйцэтгэх захирлын А/128 тоот тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна. Тус тушаал нь 2022 оны 4 сарын 13-ны өдөр Засгийн газрын тогтоолоор хүчингүй болсон “Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм”-ийг үндэслэн байгуулагдсан байна. Маргаан таслах комисс нь 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм”-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй, дарга, нарийн бичгийн дарга нарыг сонгоогүй, ажлын тайлангаа нийт ажилтан болон аймгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна.

Мөн өргөдөлд компани ажилтнуудын жишиг цалинг тогтоохдоо хэн нэгэнд хүн зориулан ялгавартай, хувийн ашиг сонирхлын дагуу албан тушаалаа урвуулан ашиглан өөрийн хамаарал бүхий хүмүүсийн ажлын байр өөрчлөгдөх, солих үед үндэслэлгүй цалингийн сүлжлийг шатлал ахиулан нэмэгдүүлж байсныг дурдах зүйтэй гэсэн байна. Албан тушаалын цалингийн шатлалд оруулсан өөрчлөлт бүрийг ашиг

сонирхлын зөрчилтэй гэж үзвэл тус асуудлыг хянаж шийдвэрлэдэг холбогдох хуулийн байгууллагад тус өргөдлийг шилжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ: Ажилтан Д.Бүтэмжидийн өргөдлийг хянаж үзээд Архив бичиг хэргийн ажилтны албан тушаалын шатлалыг “ДБЭХС ТӨХК-ийн инженер техникийн ажилтан ба зарим албан тушаалтны сарын цалингийн жишиг”-ийн 1 дүгээр шатлалаас 3 дугаар шатлал руу ахиулж үндсэн цалинг нь 598,070 төгрөгөөр нэмэгдүүлсэн нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бусад жишиг албан тушаалын ангиллын хүрээнд үндэслэлтэй шийдвэрлээгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Захиргаа удирдлагын хэлтэс “Маргаан таслах комисс”-ыг “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм”-д заасны дагуу хуралдуулж ажилтан М.Бүтэмжидийн өргөдлийг хэлэлцэж албан ёсны шийдвэр гарган нийт ажилтнуудад танилцуулж, аймгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.
2. Захиргаа удирдлагын хэлтэс тушаал шийдвэр гаргахдаа шинэчлэн батлагдсан Засгийн газрын тогтоол зэрэг эрх зүйн баримтыг зөв үндэслэн гаргаж байхыг анхаарах.
3. Шинээр нэмэгдсэн ажлын байрнаас бусад тогтсон ажлын байрны албан тушаалын шатлалыг ЗУХ үндэслэлгүй, тушаал шийдвэргүйгээр өөрчлөхгүй байх.
4. Архив бичиг хэргийн ажилтан болон Захирлын туслахын албан тушаалын шатлалыг 2022 оны жишгээр мөрдүүлэх.

ТАНИЛЦСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ХЯНАСАН:  
ДХА-НЫ ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:  
ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТАН



Г.ОТГОНБААТАР

Н.БААСАНПҮРЭВ

У.ЭНХЧИМЭГ

*Зургаан дахь  
Зөвлөмжийн дүрэм  
Хөдөлмөрийн эрхийн  
Хяналтын алба  
Танилцуулга  
10/11/15*